

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ГУРАВ ДАХЬ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ
ТАНИЛЦУУЛГА**

2025 оны 10 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.4-т заасны дагуу нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусгасан төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамт Та бүхэнд хүргүүлсэн.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар дээрх хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өөрчлөгдсөн байгааг тодруулж, хэрэглээний үнийн өсөлтийн түвшин 7.0 хувь байсныг 7.5 хувь болж өөрчлөгдсөн талаар болон ахмад настны тэтгэвэр, эмч, багш нарын цалинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор төсвийн урсгал зардал өөрчлөгдсөн тохиолдолд төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүд дахин өөрчлөгдөх эсэх, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нэгдсэн төсвийн орлого, зарлагыг тус тус 490.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг хангасан эсэх, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлттэй танилцаж, энэ асуудлаар эргэн хэлэлцэх боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа инфляци 7.5 хувь болж өссөнтэй холбоотойгоор Монголбанкнаас инфляцийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар, мөн уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит хуулийн этгээдүүдийн улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашиг, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны

төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж, төслийн эцсийн хувилбарыг бэлтгэсэн талаарх танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

